



ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 02 өдөр

Дугаар A/619

Хэрлэн сум

Хурдан морины уралдаан зохион байгуулахыг хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 57 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд бооцоот болон хурдан морины уралдаан, сунгаан, үсэргээ зохион байгуулахыг жил бүрийн 11 дүгээр сарын 01-ээс дараа оны 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хориглосугай.

2.Дурдсан хугацаанд бооцоот болон хурдан морины уралдаан, сунгаан, үсэргээ зохион байгуулахгүй байхыг иргэд, нийт уяачдад сурталчлан таниулах ажлыг зохион байгуулахыг Цагдаагийн газрын дарга (Э.Жавхлантөгс), Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга (Х.Уртнасан), "Сэцэн ханы хүлэг" уяачдын холбоонд тус тус үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нар, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газрын дарга (Э.Жавхлантөгс), Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газрын дарга (Х.Уртнасан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Д.АЮУРБУНЬ